



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/158/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум  
2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхцэцэг**

Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Уваа уул" аудит ХХК**

Утас: 99108763 Цахим хаяг:  
[uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com) Утас:

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/228

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ЗАМЫН ҮҮД СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ГУРАВДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Д.АРИУНАА ТАНАА**

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Замын Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын Үүд сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Ариунаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020. оны 1 дүгээр сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна. СТАУС-т анх 2020 оны 1 дүгээр сарын 28-нд оруулж, СТАУС-т анх 2020 оны 1 дүгээр сарын 28-нд оруулж, тулгалтаар илэрсэн алдааг засаж дуусаад эцэслэсэн санхүүгийн тайланг 2020 оны 2 дугаар сарын 16-нд оруулсан байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүүхэд хөгжлийн төвтэй чанартай боловсрол чадварлаг иргэн бэлтгэхэд оршино.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суурь болон бүрэн дунд боловсрол үйлчилгээг хүргэх,
- Холбогдох хууль тогтоомж бодолго, журмыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХАОАТ-ын тухай хууль
- Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05, 06, 07 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 24, 25 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.04.03-ны өдрийн 126 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019.10.30-ны 395 дугаар тогтоол
- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ACOLOUR программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2019 оны нийт зардал 1,667,633.0 мянган төгрөгөөс тооцон 16,676.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,583.9 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үеэс өөрчлөлт орсон байна. Төлөвлөлтийн үед урьдчилсан байдлаар гарсан тайлангаас тооцсон байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 346,735.1 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,718.5	1,718.5
Авлага	3,654.5	5,912.9	2,258.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	196,839.5	178,248.7	18,590.7
Үндсэн хөрөнгө	3,972,186.9	3,981,348.0	9,161.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,172,680.9</b>	<b>4,167,228.1</b>	<b>5,452.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,172,680.9	4,167,228.1	5,452.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,172,680.9</b>	<b>4,167,228.1</b>	<b>5,452.8</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Багшийн ажлын байранд нь тулгуурлан хөгжүүлэх” сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 2019-2020 онд он дамжин хэрэгжих хөтөлбөрийн 2020 онд зарцуулагдах хэсгийг төвлөрүүлэн шилжүүлж, авлага үүсгэсэн нь нөлөөлжээ

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 205,713.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 224,304.3 мянган төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

Хандиваар 47,046.1 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, бүртгэсэн. Актласан бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн өсөлт нь шилжиж ирсэн хөрөнгийн элэгдэл ба данснаас хасалтын элэгдлийн зөрүү байна.

2019 оны аудитын дүнгээр аудитын явцад Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн албаны шийдвэр гаргуулж, машин тоног төхөөрөмжийн данснаас 12,488.4 мянган төгрөгийн, бараа материалын данснаас 114,061.2 мянган төгрөгийн хөрөнгийг, нийт 126,549.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тавилга эд хогшлын дансанд шилжүүлж, залруулга хийсэн. Төсвийн хөрөнгөөр 3,754.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэгдсэн байна. Хандиваар 22,239.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч, бүртгэсэн. Замын-Үүд сумын ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор Замын-Үүдийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулиас 19,278.5 найман мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, бүртгэсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,167,228.1 мянган төгрөг болж, 5,452.8 мянган төгрөгөөр өссөн нь Тайлант үеийн үр дүн 5,452.8 мянган төгрөг гарсантай холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль тайлант онд 1,529,506.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,529,506.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 1,529,506.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,529,506.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,173,207.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 356,299.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,512,287.2 мянган төгрөг болж, 17,219.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Үндсэн үйл ажиллагааны орлогоор 9,594.1 мянган төгрөгийн, хөтөлбөрийн 13,500.0 мянган төгрөг, нийт 23,094.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал засварт 2,720.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1,403.0 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 96.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 13,809.0 мянган төгрөг, нийт 18,604.0 мянган төгрөг зарцуулж, 4,490.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж, нийт 25 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 266,622.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 262,059.6 мянган төгрөгийн залруулга хийгдэв. Аудитаар илэрсэн 4,562.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгөв.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,510.8 мянган төгрөгийн авлагын бүртгэлтэй холбоотой төлбөрийн акт тогтоосноос 2,510.8 мянган төгрөгийн актыг бүрэн барагдуулсан.

Худалдан авалттай холбоотой Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох заавар, журмыг 2019 онд хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 4,562.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 16,583.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Өдөрт олгох унаа, хоолны хөнгөлөлтийн дүн өндөр байна. 2. Унааны хөнгөлөлтийг нийтийн тээврээр ажилдаа ирж, очих зардлын 1 талыг хөнгөлөхөөр заасан байдаг боловч Замын-Үүд эд нийтийн тээвэр байхгүй учир таксигаар зорчдогоос таксины 1 талын зардлаар тооцож олгож байна.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2. *“Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно.”* , Төсвийн тухай хуулийн 5.1. *“Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3. санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”* заалтыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Зардал өсөх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Дээрх эрхийн актуудыг мөрдөж ажиллах.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

## **3.2. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал**

### 3.2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодогчид балансын шагнал олгохдоо Сангийн сайдын тушаалаар баталсан журмын дагуу зохих шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй, Аймгийн СТСХ-ээс зөвшөөрөл аваагүй.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Зардал өсөх.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх эрхийн актуудыг мөрдөж ажиллах.

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

## **3.3. Зардлын данстай холбоотой асуудал**

### 3.3.1 Илрүүлэлт:

Бичиг хэргийн ажилтан Я.Золзаяаг 2 сарын хугацаатай чөлөө авсан багшийн оронд ажиллуулахаар шийдвэрлэж гаргасан тушаалд *"цагийн багшаар ажиллуулж, цалинг ТҮБД-3-2-оор 699637 төгрөгөөр олгох..."* гэсэн боловч нягтлан бодогч *"багшийн илүү цагийн хөлс"* хэлбэрээр олгосон нь тушаалын заалттай нийцэхгүй байна.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1. *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."* заалтыг зөрчсөн байна.

### 3.3.2 Эрсдэл:

Зардал өсөх.

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх эрхийн актуудыг мөрдөж ажиллах.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

## **3.4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт**

### 3.4.1 Илрүүлэлт:

Үйлчилгээний ажилтнуудад ур чадвар нэмэгдэл олгохдоо ХАБХСайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар баталсан шалгуур үзүүлэлтээр бус, харин ур

чадвартай холбоо багатай үзүүлэлтүүдийг өөрсдөө бий болгон, түүгээрээ дүгнэн олгодог.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4. “Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.”, ХАБХСайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

#### 3.4.2 Эрсдэл:

Зардал өсөх.

#### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх эрхийн актуудыг мөрдөж ажиллах.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

### **3.5. Зардлын данстай холбоотой асуудал**

#### 3.5.1 Илрүүлэлт:

Цахилгаанчин мужааны , бичиг хэргийн ажилтанд ХАБЭА-ны батлагдаагүй орон тоог хавсарсан нэмэгдэл олгосон бөгөөд хавсарсны нэмэгдлийг өөрийнх нь хашиж буй албан тушаалын цалингаас тооцож олгосон.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төвийн тухай хуулийн 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох тус тус зөрчсөн байна.

#### 3.5.2 Эрсдэл:

Зардал өсөх.

#### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх эрхийн актуудыг мөрдөж ажиллах.

#### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,817,001.27	79,400,687.27
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	200,494,005.40	184,161,639.10
33	АВЛАГА	3,654,517.40	5,912,904.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,143,627.40	1,377,369.00
335	Бусад авлага	2,510,890.00	4,535,535.00
3351	Байгууллагаас авах авлага	2,510,890.00	4,535,535.00
35	БАРАА МАТЕРИАЛ	196,839,488.00	178,248,735.10
351	Түүхий эд материал	28,016,183.00	28,016,183.00
35110	Тусгай зориулалттай материал	28,016,183.00	28,016,183.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	41,955,048.00
354	Хангамжийн материал	167,698,305.00	107,152,504.10
35410	Бичиг хэргийн материал	7,689,789.00	5,825,640.00
35420	Аж ахуйн материал	157,950,956.00	98,467,604.10
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	48,200.00	1,061,900.00
35470	Бусад хангамжийн материал	1,809,360.00	1,797,360.00
35600	Мал амьтад	1,125,000.00	1,125,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,972,186,939.07	3,981,348,031.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,972,186,939.07	3,981,348,031.99
392	Биет хөрөнгө	3,779,262,939.07	3,789,348,031.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,578,291,000.00	3,578,291,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,939,697.22)	(69,577,880.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	198,726,553.55	224,358,424.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,059,822.86)	(163,670,350.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,137,640.00	257,937,360.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,869,164.40)	(55,341,144.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,640,000.00	2,640,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(264,000.00)	(792,000.00)
39217	Ном	9,600,430.00	15,502,622.00
393	Биет бус хөрөнгө	192,924,000.00	192,000,000.00
39301	Програм хангамж	924,000.00	924,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(924,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	192,000,000.00	192,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,172,680,944.47	4,165,509,671.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,172,680,944.47	4,165,509,671.09
51	Засгийн газрын хувь оролцоо	4,172,680,944.47	4,165,509,671.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,770,291,000.00	3,770,291,000.00
51101	Өмч: - төрийн	3,770,291,000.00	3,770,291,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	402,389,944.47	395,218,671.09
51210	Өмнөх үеийн үр дүн	402,389,944.47	402,389,944.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(7,171,273.38)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,172,680,944.47	4,165,509,671.09

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,025,639,371.32	1,987,638,070.50
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,272,638,228.38	1,651,221,607.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,647,228.38	108,215,007.02
120	Нийтлэг татварын бус орлого	37,647,228.38	108,215,007.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,646,228.38	108,215,007.02
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,594,150.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,054,506.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,591,722.38	98,620,857.02
120009	Бусад орлого	1,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	369,799,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,234,991,000.00	1,173,207,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	356,299,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	356,299,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,323,776,722.56	1,658,392,880.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,323,776,722.56	1,658,392,880.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,263,727,094.58	1,581,587,850.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	742,923,925.48	953,162,491.40
210101	Үндсэн цалин	498,249,184.00	546,448,870.40
210102	Нэмэгдэл	176,924,010.00	285,779,984.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	25,396,001.00
210104	Урамшуулал	67,750,731.48	95,537,636.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,525,723.14	122,822,152.00
210201	Тэтгэврийн даатгал	57,985,123.47	85,375,895.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,708,119.93	6,842,824.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,135,149.92	9,562,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,427,029.98	1,903,858.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,270,299.84	19,137,575.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	336,747,188.00	338,237,917.00
210301	Гэрэл, цахилгаан	11,621,890.00	9,416,506.00
210302	Түлш, халаалт	312,873,558.00	318,066,244.00
210303	Цэвэр, бохир ус	12,251,740.00	10,755,167.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,808,096.00	5,134,492.00
210401	Бичиг хэрэг	2,984,882.00	1,843,086.00
210402	Тээвэр, шатахуун	580,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	963,714.00	1,036,416.00

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	-	135,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,300.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,061,200.00	1,519,010.00
2105	Нормативт зардал	440,000.00	24,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	24,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,984,400.00	5,214,300.00
210604	Урсгал засвар	1,984,400.00	5,214,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,986,700.00	4,898,300.00
210702	Дотоод албан томилолт	1,986,700.00	4,898,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	2,770,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	2,770,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,811,061.96	149,323,948.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,499,606.00	5,098,725.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,786,986.00	3,049,186.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,524,469.96	141,176,037.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,049,627.98	76,805,030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,046,500.00	59,585,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,184,100.00	58,523,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,862,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,062,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,127.98	17,219,430.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,127.98	17,219,430.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-51,138,494.18	-7,171,273.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-51,138,494.18	-7,171,273.38

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,253,046,506.00	1,554,319,224.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,253,046,506.00	1,552,600,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,055,506.00	9,594,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,055,506.00	9,594,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,054,506.00	9,594,150.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,594,150.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,054,506.00	-
120009	Бусад орлого	1,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,234,991,000.00	1,543,006,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,234,991,000.00	1,173,207,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	356,299,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	356,299,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,253,046,506.00	1,548,845,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,046,506.00	1,548,845,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,193,221,378.02	1,469,608,295.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	743,673,813.00	953,515,712.00
210101	Үндсэн цалин	498,249,184.00	546,802,091.00
210102	Нэмэгдэл	176,924,010.00	285,779,984.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	25,396,001.00
210104	Урамшуулал	68,500,619.00	95,537,636.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,621,799.02	122,702,673.00
210201	Тэтгэврийн даатгал	57,081,199.35	85,256,416.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,708,119.93	6,842,824.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,135,149.92	9,562,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,427,029.98	1,903,858.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,270,299.84	19,137,575.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,062,478.00	337,922,627.00
210301	Гэрэл, цахилгаан	11,621,890.00	9,416,506.00
210302	Түлш, халаалт	312,873,558.00	318,066,244.00
210303	Цэвэр, бохир ус	12,567,030.00	10,439,877.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,618,090.00	5,247,148.00
210401	Бичиг хэрэг	799,940.00	710,960.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	898,530.00	1,493,748.00

Дорноговь аймгийн Замын Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	501,320.00	92,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,300.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	2,414,500.00
210502	Хоол, хүнс	00.00	518,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,896,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,216,100.00	13,220,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	2,716,100.00	6,220,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,386,700.00	4,898,300.00
210702	Дотоод албан томилолт	1,386,700.00	4,898,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	2,075,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,075,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,842,398.00	27,611,835.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,547,934.00	12,059,025.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,294,464.00	15,552,810.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,825,127.98	79,237,555.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,822,000.00	57,528,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,959,600.00	56,328,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,862,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,127.98	21,709,555.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,127.98	21,709,555.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	3,754,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,754,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,754,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,754,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,754,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-3,754,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,770,291,000.00</b>	-	<b>402,389,944.47</b>	<b>4,172,680,944.47</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(7,171,273.38)	(7,171,273.38)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,770,291,000.00</b>	-	<b>395,218,671.09</b>	4,165,509,671.09

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,529,506,600.00	1,512,287,170.00	17,219,430.00	98.
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,529,506,600.00	1,512,287,170.00	17,219,430.00	98.8
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,471,978,300.00	1,454,759,170.00	17,219,130.00	98.8
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	954,198,600.00	953,515,712.00	682,888.00	99.9
Үндсэн цалин	543,734,600.00	546,802,091.00	(3,067,491.00)	100.5
Нэмэгдэл	285,777,400.00	285,779,984.00	(2,584.00)	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	27,090,000.00	25,396,001.00	1,693,999.00	93.7
Урамшуулал	97,596,600.00	95,537,636.00	2,058,964.00	97.8
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	124,261,500.00	122,702,673.00	1,558,827.00	98.7
Тэтгэврийн даатгал	84,497,640.00	85,256,416.00	(758,776.00)	100.9
Тэтгэмжийн даатгал	7,952,972.00	6,842,824.00	1,110,148.00	86.0
ҮОМШӨ-ний даатгал	9,940,640.00	9,562,000.00	378,640.00	96.1
Ажилгүйдлийн даатгал	1,988,368.00	1,903,858.00	84,510.00	95.7
Эрүүл мэндийн даатгал	19,881,880.00	19,137,575.00	744,305.00	96.2
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	352,799,600.00	337,922,627.00	14,876,973.00	95.7
Гэрэл, цахилгаан	11,900,000.00	9,416,506.00	2,483,494.00	79.1
Түлш, халаалт	315,198,000.00	318,066,244.00	(2,868,244.00)	100.9
Цэвэр, бохир ус	25,701,600.00	10,439,877.00	15,261,723.00	40.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,750,000.00	5,652,148.00	97,852.00	98.3
Бичиг хэрэг	800,000.00	710,960.00	89,040.00	88.8
Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,493,748.00	6,252.00	99.5
Ном, хэвлэл	500,000.00	497,440.00	2,560.00	99.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
<b>Нормативт зардал</b>	2,318,600.00	2,318,500.00	100.00	100.0

Хоол, хүнс	518,600.00	518,500.00	100.00	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,500,000.00	10,500,000.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
Урсгал засвар	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	4,900,000.00	4,898,300.00	1,700.00	99.9
Дотоод албан томилолт	4,900,000.00	4,898,300.00	1,700.00	99.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,500,000.00	1,499,500.00	500.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,499,500.00	500.00	99.9
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15750000.00	15749710.00	290.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	750,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	14,999,710.00	290.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	57528300.00	57528000.00	300.00	100.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	57,528,300.00	57,528,000.00	300.00	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,328,300.00	56,328,000.00	300.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,529,506,600.00	1,512,287,170.00	17,219,430.00	98.8
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,173,207,000.00	1,170,864,543.00	2,342,457.00	99.8
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,173,207,000.00	1,170,864,543.00	2,342,457.00	99.8
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	356,299,600.00	341,422,627.00	14,876,973.00	95.8
Орон нутгийн төсвөөс	356,299,600.00	341,422,627.00	14,876,973.00	95.8
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-			

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		18,604,025.00
УРСГАЛ ЗАРДАЛ		18,604,025.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		18,604,025.00
Нормативт зардал		96,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		96,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		2,720,000.00
Урсгал засвар		2,720,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		576,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		576,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		15,212,025.00
Бараа үйлчилгээний бусад зардал		13,809,025.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,403,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		18,604,025.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		9,009,875.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,009,875.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,594,150.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/158/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нябод балансын шагналыг байгууллагын даргын тушаалаар 1 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгохдоо Сангийн сайдын 2002 онд баталсан журманд заасан шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй. Аймгийн СТСХ-ээс зөвшөөрөл ирдэггүй.	667.4	Зөвлөмж	Захирал, нябо	Д.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн
2	Үйлчилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг олгохдоо тушаалд ХАБХСайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалыг үндэслэл болгоогүй, уг тушаалаар баталсан журманд заасан бус харин өөрсдөө зохиосон шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгодог /зөвхөн 12-р сарыг зөрчилд авлаа/	1,892.1	Зөвлөмж	Захирал, нябо	Д.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн
3	Сургуулийн захиргаа болон үйлдвэрчний хорооны хооронд байгуулсан хамтын гэрээнд заасны дагуу унаа, хоолны хөнгөлөлт олгодог. Өдөрт унаанд 2000 төгрөг, хоолонд 5000 төгрөгөөр тооцож олгодог. Энэ нь: 1. дүн хэт өндөр, 2. унааны хөнгөлөлтийг нийтийн тээвэр байхгүй учир таксины төлбөрөөр тооцож олгодог зөрчил илрэв. /11, 12-р сард төсөвт тодотгол хийлгэн олгосон/	0.0	Зөвлөмж	Захирал, нябо	Д.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн

4	Тухайн жилийн бүтэц, орон тоонд батлагдаагүй орон тоог хавсарсны нэмэгдэл гэж олгож байна. Ингэхдээ хавсарч буй албан тушаалын цалингаас нэмэгдэл олгох байтал тухайн ажилтны өөрийнх нь албан тушаалын цалингаас тооцдог зөрчил илрэв. /Цахилгаанчин мужааны, бичиг хэргийн ажилтан ХАБЭА-ны батлагдаагүй орон тоог хавсарсан./	1,574.5	Зөвлөмж	Захирал, нябо	Д.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн
5	Бичиг хэргийн ажилтан Я.Золзаяаг 2 сарын чөлөө авсан багшийн оронд үндсэн ажлынх нь хажуугаар хавсран ажиллуулах тушаалд "цагийн багшаар ажиллуулж, цалинг ТҮБД-3-2-оор 699637 төгрөгөөр олгох" гэсэн боловч нябо цалин бодохдоо "багшийн илүү цаг" гэж үндсэн цалин бус нэмэгдэл хөлс хэлбэрээр 11-р сард 289981 төгрөг, 12-р сард 138745 төгрөг олгожээ.	428.7	Зөвлөмж	Захирал, нябо	Д.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн
ДҮН		4,562.7			